

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

дугаар № 01

Дархан-Уул аймаг

“Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дархан-Уул аймаг Дархан сум, Дархан нэхий ХК-ийн хурлын танхимд 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 12⁰⁰ цагт нийт 892 896 486 ширхэг хувьцаатай, хувьцаа эзэмшигчид оролцсоноор 80.77 %-ийн ирцтэйгээр хийлээ.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Э. Батсайхан	326 903 000 ш
2. Р. Сүмбэнхүү	301 008 000 ш
3. Б. Дагвацэрмаа	29 087 000 ш
4. Б. Гэрэлмаа	7 800 000 ш
5. С. Норжмаа	2 811 000 ш

6. Х. Золжаргал	17 213 000 ш
7. “ННТТ” ХХК	205 704 000 ш
8. Б. Чанцал	2 341 000 ш
9. Б. Мягмар-Өлзий	29486 ш

Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс томилсон тухай 2024 оны 01 сарын 13-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас томилогдсон тооллогын комиссын шийдвэрийг ТУЗ-ийн нарын бичгийн дарга Х. Нарантуяа танилцууллаа. Энэхүү тогтоолтой танилцаад ХЭХ-ийн тооллогын комиссын даргыг Б. Орхончимэгээр томилж, Ц. Жавзандуламыг гишүүнээр ажиллуулах саналыг хувьцаа эзэмшигч Х. Золжаргал гаргаснаар хувьцаа эзэмшигчид тооллогын комиссын дарга солих асуудлыг хоорондоо хэсэг ярилцаж, хуралд оролцогчдын 100% -ийн саналаар тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хэвээр үлдээж, тооллогын комиссын даргаар Б. Орхончимэгийг, гишүүнээр Ц. Жавзандулам, У. Азаяа, Х. Мандухай нарыг тус тус ажиллуулах шийдвэрийг шинэчлэн гаргаж, тооллогын комиссыг ажилд нь орууллаа.

Б. Орхончимэг Тооллогын комиссын дарга

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцийг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав. Тэрээр хувьцаа эзэмшигчид энэхүү хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №1-ээр, ТУЗ-ийн гишүүдийг сонгож санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №2-оор тус тус бичгээр өгнө. Харин ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал өгөхдөө Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ыг баримтлан санал өгнө гээд уг журмыг тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга Э. Батсайхан:

-Хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ талархал илэрхийлж, мэндчилье.
-Тооллогын комиссын мэдээллээр хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийн ирц 80,77%-тай байгаа тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж хурлаа эхлүүлж байна. Та бүхэндээ хурлын дэгийг танилцуулъя.
-Хурлын дэгтэй холбоотой асуудалд санал байна уу.
-Хурал оролцогч та бүгдээс өөр санал байхгүй бол хурлын дэг ёсоор хэлэлцэх асуудлыг, асуудал тус бүрээр хэлэлцсэний эцэст хувьцаа эзэмшигчид батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, тооллогын комисс эцсийн шийдвэрийг гарган дүнг танилцуулна. Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж байна. /Өнөөдрийн хурлаар 6 асуудлыг хэлэлцэнэ. Одоо хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Хэлэлцэх асуудал

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. ТУЗ-ийн гишүүнийг сонгож батлах
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож төсвийг батлах
4. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулж батлах
5. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
6. ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлыг батлах

Э. Батсайхан: /хурлын дарга/

-Та бүхэн хэлэлцэх асуудалтай танилцсан тул асуух зүйл байна уу. Асуух зүйлгүй бол дэгийн дагуу хэлэлцэх асуудалдаа орёе.

1-р асуудал:

-Дархан нэхий ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийн талаархи мэдээллийг Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн дарга Э. Батсайхан, мөн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос өгсөн дүгнэлтийг аудитын хорооны гишүүн Б. Мягмар-Өлзий нар тус тус танилцууллаа.

2-р асуудал:

Э. Батсайхан: Хурлын дарга

-ТУЗ-ийн гишүүнийг сонгож, батлах асуудлыг хэлэлцье. ТУЗ-д нийтдээ 11 иргэн нэр дэвшсэн бөгөөд үүнээс ТУЗ-ийн ердийн гишүүнд 5 иргэн, хараат бус гишүүнд 6 иргэн тус тус нэр дэвшсэн байна. ТУЗ-ийн хуучин гишүүд 2 жилээр сонгогдсон гэдгийг тодруулан хэлье. Иймээс хуучин ТУЗ-ийн гишүүд голдуу нэр дэвшсэн байгаа. Нэр дэвшигчдийн анкет, хараат бус гишүүний шалгуурыг хангасан эсэх, мөн засаглалын сургалтанд хамрагдсан талаархи мэдээллийг хүн тус бүрээр нь ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны гишүүн Х. Золжаргал товч танилцууллаа. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал өгөхдөө шинэчлэн баталсан санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ын дагуу өгөхийг хурлын дарга дахин санууллаа. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 4 нь ердийн, 5 нь хараат бус гишүүн байх нь зүйтэй гэж үзэж, асуудлыг тооллогын комисст санал тоолуулахаар шилжүүлж, дараагийн асуудалд орохоор боллоо.

3-р асуудал:

Э. Батсайхан: /хурлын дарга/

-ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, ТУЗ-ийн төсвийг уншиж танилцуулаад төсөв та бүгдийн гар дээр очсон байгаа. Төсөвтэй холбоотой асуух зүйлийг асууж саналаа өгнө үү. та бүхэнд асуулт байна уу. Төсөвт том хэмжээгээр тусгагдсан зардал нь хоолны зардал. Өмнөх оны төсөвт хоолны зардал тусгагдаагүй байсан. Цалингийн зардал 21%-иар өссөн байгаа. Тусгай үүргийн ажилтан нэмэгдсэн. Төсвийн талаар асуулга байхгүй бол төсвийн зардлыг батлуулахаар санал тоолуулахаар шилжүүлэв.

Х. Золжаргал /хувьцаа эзэмшигч/

-Асуух зүйл алгаа. Шууд саналын хуудсаар саналаа өгье. Ерөнхийдөө зөвшөөрч байна.

Р. Сүмбэнхүү /хувьцаа эзэмшигч/

-ТУЗ-ийн төсөв, урамшуулалтай танилцлаа. Санал нэгтэй байна.

-Харин хуралд оролцогчдод хандаж хэлэхэд хуралдаа идэвхитэй оролцож, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх хэрэгтэй байна.

4-р асуудал:

Х. Нарантуяа: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

-Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 18-ны өдрийн 10 тоот тогтоолыг уншиж танилцуулаад, ногдол ашиг хуваарилах нь ТУЗ-ийн эрх мэдлийн асуудал боловч КТХ-д зааснаар ХЭЭХ-д заавал танилцуулна гэсний дагуу хэлэлцэх асуудалд оруулж танилцуулж байгааг тайлбарлав. Хурлын дарга энэ асуудлыг санал тоолуулахаар шилжүүлжэ гэв.

5-р асуудал:

-КТХ-ийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайланг хурлын дарга Э. Батсайхан танилцууллаа. /Дэлгэрэнгүйг хавсралтаар/

Хувьцаа, ногдол ашгийн талаархи товч мэдээлэл:

-2024.02.02 ны бүртгэлээр 5470 хувьцаа эзэмшигч байна. 2023. 01.09-ны бүртгэлээр 4894 хувьцаа эзэмшигч байсан нь 576 хувьцаа эзэмшигчээр нэмэгдсэн. 2020.7.8-ны СЗХ-ны 96 тоот хурлаар Дархан нэхий ХК-ийн хувьцааг Дархан нэхий ХК-ийн хувьцааг 1000 дахин жижиглэж 11,5 төгрөгийн нэрлэсэн үнэтэй байхаар шийдвэрлэсэн. 2020.8.6-нд шинэ үнээр СЗХ-ны 99 тоотор арилжаа шинэ үнээр арилжаа нээгдсэн 13 төгрөгөөр өсөлттэй худалдаалагдаж эхэлсэн. Ноогдол ашиг 2022 оны ноогдол ашиг 250 сая төгрөг бүрэн хуваарилагдсан. Ноогдол ашгийн өглөг байхгүй. Компанийн ноогдол ашгийн хэмжээ нь Голомт банкаар дамжин авсан Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийн гэрээнд тусгасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ 250 сая төгрөгөөр хуваарилагдаж байгаа. Энэ байдал 2025 оны 6 сар хүртэл үргэлжилнэ. Үүнээс хойш ноогдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх эрх үүсэх юм. 2023 оны ажлын үр дүнгээр мөн л 250 сая төгрөг, нэгж хувьцаанд 0,23 төг хуваарилагдсан байгаа. Хувьцааны үнийн өсөлт анхны нэрлэсэн үнээс 64,3 хувь өсөлттэй, нэгж хувьцааны өгөөж жилийн 2,0% байна. Өнгөрсөн жилийн дундажтай харьцуулбал нэгж хувьцааны үнэ -5% уналттай байна. 2023 оны хөрөнгийн биржийн мэдээгээр 5 582 271 ширхэг буюу 105,5 сая төгрөгийн хувьцаа арилжаалагдаж, нэгж хувьцааны дундаж үнэ 18,9 төгрөг болж, нийт хувьцааны 0,5% арилжаанд орсон байна.

Э. Батсайхан:

- ТУЗ-ийн тайлантай холбоотой санал байна уу? За санал, асуулт, тодруулах зүйл байхгүй бол дараагийн асуудлыг хэлэлцье.

6-р асуудал:

Э. Батсайхан: /Хурлын дарга/

-ТУЗ-аас шийдвэрлэсэн бусад асуудал хойшлогдож байгааг мэдэгдсэнээр энэ асуудал дуусгавар болов.

-За хурлын дэгийн дагуу асуудлуудыг хэлэлцэж дууслаа. Одоо саналын хуудсаа бөглөцгөөе.

Ингээд хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууссан тул хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгч, тус бүрийн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч, дүгнэн эцсийн дүнг танилцуулж, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01, 02, 03 тоот шийдвэрийг тооллогын комиссын дарга Б. Орхончимэг уншиж танилцууллаа.

1. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналын дүн:

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ -ийн гишүүн сонгох асуудлыг батлах, ТУЗ-ийн гишүүний цалин урамшуулал, төсвийг батлах, Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-аас гаргасан шийдвэртэй танилцсаныг батлах, Компанийн тухай хуулийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайлантай танилцсаныг батлах, ТУЗ-ийн шийдвэрээр ХЭЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлыг батлах тооллогын комиссын дүнг тус тус танилцуулав.

2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын дүн:

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож, үүнээс ердийн гишүүнд 4, хараат бус гишүүнд 5 гишүүн сонгогдсон тухай дүнг танилцуулав.

1. ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

Эрдэнэдалайн Батсайхан - Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 87% -ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 70 хувийн саналаар;

Равжаагийн Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 77%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар;

Баасангийн Гэрэлмаа - Хуралд оролцогчдын 77%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар;

Батсайханы Мягмар-Өлзий - Хуралд оролцогчдын 77% -ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар;

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

Далхжавын Батжаргал - Хуралд оролцогчдын 90%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 73 хувийн саналаар;

Хумбагайн Золжаргал - Хуралд оролцогчдын 77%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар

Цоодолсүрэнгийн Хадаа - Хуралд оролцогчдын 77%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар;

Баатарын Бурмаа - Хуралд оролцогчдын 77%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар;

Ринчингийн Бямбадорж - Хуралд оролцогчдын 77%-ийн саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 62 хувийн саналаар;

тус тус сонгогдсон байна.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 03 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаас дараах шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, батлах
3. Дархан нэхий ХК-ийн 2024 оны ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, төсвийг батлах
4. "Ногдол ашиг хуваарилах тухай" ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 18-ний өдрийн 10 тоот тогтоолоор гарсан шийдвэрийг батлах
5. КТХ-ийн 96,4-д заасан ТУЗ-ийн тайланг танилцуулсныг батлах

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДАРГА

Х.НАРАНТУЯА

Э. БАТСАЙХАН